



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 01 сарын 16 өдөр

Дугаар А/11


Улаанбаатар хот

Г.Ууганбаярт чөлөө олгох тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтыг тус тус ТУШААХ нь:

1. Тус албаны Тохижилт, Хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга Гантөмөрийн Ууганбаяр Удирдлагын академийн мэргэшүүлэх дипломын сургалтын Төрийн удирдлагын Пүрэв гарагийн ангид элсэн суралцах болсон тул дотоод журмын 8 дугаар бүлгийн 8.7 дахь заалтын дагуу 2019 оны 01 дүгээр сарын 17-ноос 2019 оны 05 дугаар сарын 31-нийг дуустал 7 хоногийн бүрийн Пүрэв гарагт ажлаас чөлөөлж, цалинтай чөлөө олгосугай.

2. Чөлөөтэй байх хугацаанд ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүрэг, цаг үеийн шаардлагатай өгсөн үүрэг даалгаврыг орлон ажиллах хуваарийн дагуу холбогдох мэргэжилтэнд хариуцуулан үүрэгжүүлэхийг Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга Г.Ууганбаярт даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР

